

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-13

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвших хүсэлтийн загвар батлах тухай/ 3-12

2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргыг сонгох тухай/ 12-13

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
11 дүгээр сарын 05-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 56 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Ганхуяг, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, Б.Найдалаа, С.Цэнгүүн;

Эмнэлгийн чөлөөтэй: О.Батнайрамдал, Х.Баттулга, Ж.Ганбаатар, М.Мандхай;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, О.Цогтгэрэл.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвших хүсэлтийн загвар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж “Нэр дэвших хүсэлтийн загвар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Л.Соронзонболд, А.Ундраа, Н.Батсүмбэрэл, П.Батчимэг нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Р.Сэддорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Л.Соронзонболд, Э.Батшугар, Д.Энхтүвшин, Н.Батсүмбэрэл нар үг хэлэв.

Р.Сэддорж: “Нэр дэвших хүсэлтийн загвар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг найруулгын засвартайгаар батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 1

Бүгд: 13

92.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргыг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлыг нэр дэвшүүлэв.

Нэр дэвшүүлсэнтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагайгийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Р.Сэддорж хариулж, тайлбар хийв.

Р.Сэддорж: Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёлыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 0
Бүгд: 13

100 хувийн саналаар дэмжигдэж, энэ тухай Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж “Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолыг танилцуулж, Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны дарга Б.Мөнхсоёлд баяр хүргэж, ажлын амжилт хүсэв.

Уг асуудлыг 11 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 51 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
10 цаг 56 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Та бүхэндээ өглөөний мэнд дэвшүүлье. Байнгын хорооны эрхэм гишүүдийн амгаланг айлтгая. Оролцож байгаа гишүүдээ танилцуулъя. Оролцож байгаа гишүүд Сэддорж, Алтаншагай, Бадамсүрэн, Батболд, Батсүмбэрэл, Батчимэг, Батиугар, Бямбасүрэн, Мөнхсоёл, Соронзонболд, Ундраа, Энхтүвшин, Энхцэцэг нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Эмнэлгийн чөлөөтэй Батнайрамдал гишүүн, Ж.Ганбаатар гишүүн, Цэнгүүн гишүүн, гадаад томилолттой Х.Ганхуяг, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, М.Мандухай, Б.Найдалаа нар. Ингээд хуралдааны ирц 52 хувьтай байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл. 2.Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргыг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төсөл. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвших хүсэлтийн загвар батлах тухай/

Нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Тогтоолын төслийг хавсралтын хамт та бүхэнд тараасан байгаа. Төслийг уншиж танилцуулъя. Байнгын хороо өөрийн санаачилгаар энэ Хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу урьд нь бол ийм маягт анкет эд нар бол баталж байгаагүй юм байна. Энэ Дэгийн тухай хуультай холбогдуулаад ингээд гарч байгаа юм байна.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол. Нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.6 дахь хэсэг, Төв банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1.2.3 дахь, 1, 2, 3 дахь хэсэг, 27¹ дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг, 27³ дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.5, 11.6 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.3, 29.4, Статистикийн тухай хуулийн 13¹ дүгээр зүйлийн 13^{1.2} дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монголбанкны Ерөнхийлөгчид нэр дэвших тухай хүсэлтийн загварыг 1 дүгээр хавсралтаар, Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвших тухай хүсэлтийг хүсэлтийн загварыг 2 дугаар хавсралтаар, Монголбанкны хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн загварыг 3 дугаар хавсралтаар, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн загварыг 4 дүгээр хавсралтаар, Санхүүгийн

зохицуулах хорооны даргад нэр дэвших тухай хүсэлтийн загварыг 5 дугаар хавсралтаар, Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн загварыг 6 дугаар хавсралтаар, Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн загварыг 7 дугаар хавсралтаар, Үндэсний статистикийн хорооны даргад нэр дэвших тухай хүсэлтийн загварыг 8 дугаар хавсралтаар, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн загварыг 9 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна. Төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Батчимэг гишүүнээр тасалъя Бадамсүрэн гишүүний микрофоныг өгье.

М.Бадамсүрэн: Энэ анкетыг баталж байгаа үндэслэл нь юу вэ? 2 дугаарт нь энийг боловсруулахдаа яг хаанаас санал авсан бэ? Энэ 2-ыг асууя.

Р.Сэддорж: Гишүүний асуултад хариулъя. Дэгийн тухай хуулийг энэ зун баталсан юм байна. Энэ хууль дээрх заалтуудыг хэрэгжүүлэхийн тулд өнөөдөр ингээд хуралдаанаар орж батлагдахаар явж байна. Хуучин бол ийм анкетын загвар, анкетын загвар гэсэн үг биз дээ, ийм юм байдаггүй байсан юм байна. Зүгээр би миний зүгээр өнгөц харж байгаагаар бол жоохон хүнд суртал эд нар л нэг хэлбэр юм уу л гэж зүгээр харлаа. Тэгэхдээ ингээд хууль дээр нэгэнт гарсан зүйлийг гарснаар нь ингээд явуулахаас өөр үггүй. Бид төсөв батлаад ингээд Монголбанкны хугацаа нь дууссан хяналтын хорооны гишүүд болон бусад хүмүүсийг Эдийн засгийн байнгын хороогоороо хэлэлцүүлж, нэр дэвшигчдийн сонголыг зохион байгуулна. Тэрнээс өмнө баталж байгаа л ийм хэлбэр. Бэлтгэл хангаж байгаа. Ерөнхий

загвар нь бол нэг юм байна. Доторх зүйлүүдийг бол энэ харьяа 3 байгууллага Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хорооноос авч энэ загварыг нь боловсруулсан юм байна. Загвар, бүгдийнх нь хавсралт ард байгаа юу, байна уу? Бүгдэд нь байгаа юм байна. Баярлалаа. Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: Ингээд нэр дэвших тухай хүсэлт гээд ингээд баталчихаар аягүй олон хүн ингээд хүсэлтээ өгөх боломж болох гээд байна шүү дээ. Тэгээд ерөнхийдөө болохоор хуулиараа болохоор Төв банкны тухай хуулиараа чинь Их Хурлын дарга өөрөө санал болгоод оруулж байгаа шүү дээ. Тэгэхээр аягүй олон хүсэлт өгчихдөг. Тэгэхээр тэндээс нь Их Хурлын дарга өөрөө тодорхой хэмжээний шалгаруулалт хийгээд танилцуулах болж байна уу гэдэг 1 дүгээрт тийм асуулт байгаад байгаа юм.

2 дугаарт болохоор бол яг нэр дэвших тухай хүсэлт дээр бол тухайн салбарт ажилласан онцлог юуг нь нэлээн дэлгэрүүлж авах ёстой болов уу л гэж бодож байна л даа. Жишээлбэл Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч дээр бол ялангуяа банкны салбарт ажилласан туршилага нь бол нэлээн чухал байх ёстой болов уу гэж бодож байгаа юм. Яагаад гэхээр бид нар арилжааны банкны гүйцэтгэх захирлыг томилохдоо тухайн салбарт 10 жил дор хаяж газрын захирлаас дээш албан тушаалд ажилласан хүнийг тавьдаг. Манай Монголбанкны Ерөнхийлөгч дээр бол яах вэ ерөнхий байдаг эдийн засаг, хууль, эдийн засгийн чиглэлээр банк санхүүгийн салбарт ажилласан байх гэсэн тиймэрхүү л юу байдаг. Тэгэхээр энэ дээр зүгээр яах вэ нэг энэ юун дээр нь хэрвээ үнэхээр нэгэнт ийм хүсэлт загвар авч байгаа бол энэ дээр тиймэрхүү мэдээлэл тусгавал яасан юм бэ гэж бодож байгаа.

Үндэсний статистикийн хороо /ҮСХ/ дээр бол ялангуяа сүүлийн үед бид нар энэ дата удирдлага энэ AI-тай холбоотой асуудлууд ярьж байгаа учраас тэр чиглэлийн ажлуудын талаар эд нар бас мэдээлэл авч тусгадаг болбол илүү ҮСХ-ны юунд илүү зөв болов уу. Ялангуяа тэр ҮСХ-ны дарга болон ҮСХ-ны зөвлөлийн гишүүд дээр бол тиймэрхүү шаардлага байвал зөв болов уу л гэж бодож байна. Өөрөөр хэлбэл дата удирдлага, AI чиглэлд ажилласан туршилагын талаар нэлээн юм бичсэн байвал илүү зөв болов уу гэж бодож байна. Ийм саналтай байна.

Р.Сэддорж: Мэдээж нээлттэй явна. Олон нийтэд бол нээлттэй ил зарлана. Хүний эрхийн асуудал хэнд ч өрсөлдөж болно. Сонсгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу сонсголыг зарлаж зохион байгуулна. Мэдээллийг бол Байнгын хорооны гишүүдэд бол нээлттэй ирүүлнэ. Ингээд энэ дотор бол төрийн албан хаагчдын анкет, эрх бүхий албан байгууллагаас нэр дэвшүүлсэн албан бичиг, шийдвэр, иргэний үнэмлэхийн хуулбар, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг, боловсролын зэргийн дипломын хуулбар, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, тухайн албан тушаалыг хашихад шаардлагатай түвшиний мэдлэг, чадвар, туршилага, ёс зүйтэй гэдгийг нотлохыг харуулсан 10-аас доошгүй тодорхой үйл ажиллагааны талаарх баримтууд, энэ загварт заасан баримт бичгүүд бүгдээрээ, холбогдох бусад бичиг баримтууд гээд энэ зүйлүүд бүгд орно.

Яг өөр өөрийн холбогдох хуулиуд дээр нь бол шаардлагууд нь тавигдчихсан байгаа 3 байгууллагын. Таны гаргасан энэ саналыг бол албан ёсоор протоколд авлаа. ҮСХ-ны зөвлөлийг сонгохдоо дата удирдлага, AI гээд энэ технологиудыг мэддэг туршилагатай хүмүүсийг авъя гэсэн энэ протоколд тэмдэглэж тусгалаа. Асуулт санал гэж ойлголоо.

Дараагийн гишүүн Ундраа гишүүний микрофоныг.

А.Ундраа: Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Тогтоолын төсөл энэ хавсралтуудыг харж танилцлаа. Тэгээд яах вэ зарчмын хувьд манайх иргэдэд мөн ажилд хандахад жишээлбэл нэг тийм социалист маягийн асуултууд асуух нь байдаг. Жишээлбэл нийгмийн гарал үүсэл ажилчин, малчин, сэхээтэн гэдэг дээр үеийн социализмын юмыг асуугаад байгаа юм уу эсхүл гавьяа шагнал гээд л тэгэхээрээ тийм одон медаль, ийм тэдэн жилийн ойн медаль энэ тэр гэсэн юмнуудыг бичүүлэхийг шаардаад байгаа юм уу гээд ингээд тиймэрхүү асуултуудыг харахаар их хуучинсаг харагддаг байсан л даа. Тэгээд тэрийг бол өөрчлөх ёстой гэж бодож явдаг. Тэгээд энэ нэр дэвших тухай хүсэлт дээр тийм чиг хандлагатай асуултууд байхгүй байна. Энэ тэр утгаараа сайн байна гэж бодож байна.

Бас ерөнхийдөө нөгөө тухайн эрхэлсэн ажилтай нь холбоотой туршилага, тэгээд бол эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх, ялагдагчаар татагдаж байсан эсэх тийм ээ, мэргэжлийн холбоо байгууллагын гишүүнчлэлийн талаар, бас нэмэлтээр асууж байгаа энэ боловсруулсан, хянасан судалгааны ажил ном, өгүүлэл, тайлан, Олон улсын байгууллагуудад ажиллаж байсан, илтгэл тавьж байсан гээд эдгээр асуудлуудыг нь асууж байгаа нь бас мерит зарчмыг танилцуулахад зөв зүйтэй асуултууд болж гэж харагдаж байна.

Та бүхэн нийгэмд гардаг түгээмэл шүүмжлэлүүдийг харах юм бол жишээлэхэд Монголбанкны удирдлагуудын хувьд банк бус санхүүгийн байгууллага хувьдаа эзэмдэг, ингээд сонирхлын зөрчилтэй байдгаас болоод зээлийн хүүг бууруулахгүй байх тийм бууруулахгүй байх сонирхолтой юм биш үү гэдэг ийм хардлага сэрдлэг бол маш их байдаг. Тэгээд тэр үүднээсээ ер нь сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлыг

нь маш сайн тодруулж асуух нь зүйтэй. Тэрэнтэй холбоотой дүгнэлтийг хавсаргасан байх нь байхыг шаардах нь зөв гэж бодож байна.

Бас Санхүүгийн зохицуулах хорооны даргыг хэдэн жилийн өмнө бол жишээлэхэд тэр СЗХ хяналт тавьдаг байгууллагууд нь мэргэжлийн холбоод нь бид нарт санхүүжилт өгч байна, өгөхгүй байна гэдэг шалтгаанаар бараг шахуу ингээд сонирхлын зөрчилтэйгөөр нэг зохицуулах байгууллагатайгаа өөрсдөө нэг талд гарч суучаад, тэгээд өөрсдийгөө зохицуулуулахгүй байх юу байх гээд байгаа юм биш үү гэж бүүр тухайн үед бодогдож байсан. Тэгэхээр СЗХ гэдэг бол хяналтын чиг үүрэг, тэр зохицуулах асуудлаа хийхдээ нөгөө мэргэжлийн холбоодтойгоо нэг талд гараад суучаж болохгүй биз дээ. Тэгээд зарчим алдагдана. Тэгээд ийм байдлаар нөгөө сонирхлын зөрчилтэй байх хүсэлтэйгээр компани явуулаад, тэгээд даргыг нь огцуулж байсан. Тэгэхээр муухай ааштай гэдэг үндэслэлээр. Үгүй ээ тэр чинь зарчмын асуудлаа харах ёстой болохоос биш хүний ааш занг шүүж байх ёстой юм уу, хуулийн дагуу ажилласан эсэх нь чухал юм уу. Тэгэхээр ийм байдлууд бол харагдсан.

Тэгэхээр энэ дээр энэ зарчмын сонирхлын зөрчлөөс ангид байх, тэгээд хэнийг хэн зохицуулах гэж байгаа гэдэг нь бол маш тодорхой байх, ил тод байх зарчим их чухал гэж бодож байна. Тэгээд энэ дээр Байнгын хорооны даргын.../минут дуусав/

Р.Сэддорж: Ундраа гишүүнтэй санал нэг байна. Сая Соронзонболд гишүүний саналыг ч авсан. Байнгын хорооны гишүүд бол энэ дээр тогтоолын хавсралт дээр байгаа зүйл заалтыг бол хасаж болно, нэмж болно гэсэн ийм эрхтэй. Тийм учраас гишүүдийн саналыг авна, одоо бас хасаж болно. Тэгэхээр та бүхэн саналуудаа протоколд тэмдэглүүлээд ингээд явах нь. Тэгээд энэ бас хувь хүний бас энэ ял гавьяа эд нар

чинь бас бодох л асуудал байгаа. Дээрээс нь бол яг саяын хэлдгээр бол тэр хувьдаа тийм байгууллагатай хүмүүс ажиллах нь бол угаасаа ёс зүйд болохгүй. Энэ чинь бол энэ сонирхлын зөрчлийн хууль чинь бол бүр нарийн гарчихсан байгаа. Тэгэхээр энийг бол хавсаргах хэрэгтэй гэдэгтэй бол санал нэг байна. Монголбанк, СЗХ, ҮСХ энэ 3 дээр бол санал нэг байна. ҮСХ ч бас гайгүй байх. Нөгөө 2 дээр бол ямар нэгэн байдлаар ийм юмнуудыг анхаарч явах хэрэгтэй гэдэг дээр бол санал нэгтэй байна. Санал нэг, тийм. Дараагийн гишүүн Батсүмбэрэл гишүүний микрофоныг нээе.

Н.Батсүмбэрэл: Энэ Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийг дагаж хэрэгжүүлэхтэй холбоотой орж ирж байгаа асуудал юм байна гэж ойлголоо. Тэгээд Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Монголбанкны хяналтын зөвлөлийн дарга, гишүүд, Монголбанкны бодлогын хорооны гишүүд, СЗХ-ны дарга, СЗХ-ны гишүүд, СЗХ-ны хяналтын зөвлөлийн дарга, гишүүд, ҮСХ-ны дарга, ҮСХ-ны зөвлөлийн гишүүд гээд субъектүүд байгаад байгаа юм байна. Энэ нийтдээ хэдэн орон тоо байна вэ? 1 дүгээрт нийт хэдэн орон тоо вэ? Энэ 9 хавсралтаар батлагдаж байгаа орон тоо хэдэн хүний асуудал байна вэ 1 дүгээрт?

2 дугаарт үүнтэй холбоотойгоор нэгэнт нэр дэвшүүлэх асуудал яригдаж байгаатай холбоотойгоор хугацаа нь дуусчихсан албан тушаалтан байгаа юу? Энэ субъектүүд дотор, бүрэн эрхийн хугацаа гэж байгаа шүү дээ томилогдсон. Тэр нь дуусгавар болчихсон хүн бий юу? Дуусгавар болчихсон хүний асуудал хэрхэн шийдэх юм бэ? Хугацаа нь дуусгавар болоогүй хүний асуудал хэрхэн шийдэх юм бэ? Хугацаа нь болоогүй хүмүүсийн.

Саяын Ундраа гишүүний ярьсантай санал нэг байна. Энэ ашиг сонирхлын зөрчлийн асуудал мэр сэр хэвлэлээр ч гардаг, дуулддаг. Ялангуяа энэ Монголбанк, СЗХ банк бус санхүүгийн

байгууллага хувьдаа эзэмшдэг, оролцдог тухай. Зарим банкны төлөөлөл байдаг тухай яриа байдаг. Үүнийг хэрхэн энэ дээр тусгаж байгаа юм бэ?

Үүрэг биелүүлэх байдлыг хэрхэн авч үзэх юм бэ? Өөрөөр хэлбэл хамгийн эхнийх энэ Монголбанкны мөнгөний тогтвортой бодлогыг барих үүрэгтэй шүү дээ. Энэ валютын ханишийн өөрчлөлт, төгрөгийн ханишийн сулралтыг хэрхэн зохион байгуулж ажиллаж байгаа вэ? Үүнийг энэ дээрээ яаж мэргэжлийн талаас нь тусгасан уу?

Тэгээд сүүлийн асуулт энэ манай Байнгын хороо дангаараа үүнийг шийдэх үү, ХЗБХ юм уу бусад Байнгын хороодоос санал авах, зөвшилцөх асуудал хуулийн хүрээнд гарах шаардлагагүй гэж үзэж байгаа юу? Энэ мэргэжлийн маягтай асуулт дээр тэгээд Байнгын хороон дарга байх юм уу, ажлын албаны дарга байх юм уу тэгээд тодорхой хариулт протокол дээр үлдээе.

Р.Сэддорж: Би эхлээд мэдэж байгаагаа хариулчихъя. Монголбанкны хяналтын зөвлөл 6 хүнтэй, СЗХ-ны хяналтын зөвлөл 6 хүнтэй. Нийт энд саяын бид нар анкетыг нь загварыг нь батлах гээд байгаа энэ албан тушаалуудын тоог бол одоо гаргаад ирье. 20 гаруй хүн байгаа. Энэ 6, 6 хяналтын зөвлөлийн хүмүүсийн хугацаа нь бол дууссан, хүлээгдэж байгаа. Бусад асуудлын талаар манай Байнгын хорооны ахлах референт хариулна. Ахлах референтийн микрофоныг нээе. Индэр дээр.

Д.Мягмарцэрэн: Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Мягмарцэрэн байна. Нэр дэвшигчийн хүсэлтийн загвар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг бол Байнгын хороо Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.6-д заасны дагуу Байнгын өөрийнхөө санаачилгаар өөрөө

боловсруулж баталж байгаа. Энэ дээр 36 дээр нэр дэвшигчийн дэлгэрэнгүй танилцуулга, томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвисэн үндэслэл, тухайн албан тушаалд тавигдах хуульд заасан нийтлэг болон тусгай шаардлагын талаарх мэдээллийг авах маягтын загварыг Байнгын хороо батална гэж заасан байгаа. Тэгээд энэ дагуу энэ тогтоолын төслийг Байнгын хороо өнөөдөр ингээд хэлэлцэж байгаа.

Одоогоор бол сая Байнгын хорооны даргын хэлснээр бол Монголбанк, СЗХ-ны хяналтын зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь дууссан байж байгаа. Байнгын хороо нөгөө Хяналт шалгалтын тухай хууль, Дэгийн тухай хуульд заасны дагуу ингээд нэр дэвшигчийнхээ маягтыг эхэлж батлаад, энэ дагуугаа олон нийтэд нөгөө нэр дэвших хүсэлтийг нь хүлээж байгаагаа зарлаад, тэгээд дараа нь сонсгол явуулаад, тэгээд Байнгын хорооноос тавьсан шаардлага, Байнгын хорооноос болон хуульд заасан шаардлага шалгуурыг хангасан нэр дэвшигчдийг Их Хуралд оруулж танилцуулж, томилуулдаг ийм дэгтэй байж байгаа.

Энэ бусад нөгөө Байнгын хороотой хамтрахын хувьд бол Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Статистикийн хороонууд бол зөвхөн Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын харьяа байгууллагууд учраас Эдийн засгийн байнгын хороо дангаараа энэ нэр дэвшигчдийн нөгөө материалыг хүлээж авах ийм эрхтэй байгаа.

Р.Сэддорж: Тодруулга
Батсүмбэрэл гишүүний микрофоныг нээе.

Н.Батсүмбэрэл: Тэгэхээр 1 энэ материал бүрдүүлэхдээ бид нар чинь загвар баталж байна. Энэ материал бүрдүүлэх ажил ингээд анх удаагаа хийгдэх юм шиг байна ойлгосноор. Материалыг буруу бүрдүүлсэн эсхүл санамсаргүй байдлаар алдаа гаргасан бол яах вэ 1 дүгээр асуудал?

2 дугаар асуудлын тогтоолын 2 дахь заалт буюу батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө гэж байна. Тэгээд хугацаа нь дуусчихсан хүмүүсийнхээ асуудлыг хэзээ авч хэлэлцэх вэ?

Р.Сэддорж: Ажлын албанаас индрийн микрофоныг нээе.

Д.Мягмарцэрэн: Нэр дэвшигч материалаа буруу бүрдүүлэх, алдаа гаргах энэ тэрийг бол 100 хувь өөрөө хариуцаж байгаа. Тэгээд нэр дэвшигч буруу материал бүрдүүлж өгч алдаа гаргадаг ч юм уу эсхүл хууран мэхлэх үйлдэл гаргах юм бол Байнгын хороо тухайн нэр дэвшигчийг нэр дэвшүүлэх, томилохоос татгалзах бүрэн эрхтэй байж байгаа.

Дараагийн асуулт нь юу билээ, хэзээнээс тийм. Тэрийг бол ингээд энэ манайх анкетаа загвараа баталсны дараагаар олон нийтэд зарлана. Тэгээд нэр дэвшигчийн материалууд ирсний дараагаар сонсголоо товоо зарлана, бас жоохон хугацаа орно. Тэгэхээр 11 сардаа аягүй бол амжихгүй ч байж магадгүй. Их Хурлаар оруулах томилох бүрэн нөгөө процесс дуусах хүртэлх хугацаа нь.

Р.Сэддорж: Төрийн шуурхай байдал эд нар гэдэг чинь яаралтай горимоор оруулаад, энэ хугацаа нь дууссан хүмүүс чинь янз бүрийн шийдвэр гаргавал тэгээд хэн хариуцлага хүлээх вэ? Энэ дээр манай ажлын алба яаравчлах хэрэгтэй л гэж үзэж байна. Өнөөдөр ингээд батлагдвал. Тэгээд энд юу яагаад байх зүйл юу байдаг юм бол, хугацаа аваад байх зүйл. Тэгэхээр яаралтай шийдвэл зүгээр байх гэсэн ийм Батсүмбэрэл гишүүний саналтай бол нэг байна. Би бас саналаа хэлээд явчихъя. Батчимэг гишүүн микрофон нээе.

П.Батчимэг: Та бүхэнд энэ өглөөний мэнд хүргэе. Зарим нэг асуулт гишүүдтэй давхацлаа. Тэгээд ер нь энэ Монголбанкны Ерөнхийлөгч болон СЗХ-ны

даргын нэр дэвших тухай хүсэлт энэ анкет ингээд ижил байгаад байна л даа ер нь хоорондоо. Тэгэхээр загвар нэгэнт сонгон шалгаруулалтын загвар нэгэнт анх удаа батлагдах гэж байгаа бол энэ анкетын загварт өөрчлөлт оруулж болох уу 1 дүгээрт?

Тэгээд ер нь Монголбанкны Ерөнхийлөгч, СЗХ-ны дарга 2 чинь 2 өөр төрлийн албан тушаал. Тэгэхээр энд юу ялгаатай нэг тийм юунууд орж баймаар байна л даа, ормоор байна л даа. Жишээ нь Монголбанкны Ерөнхийлөгч, СЗХ-ны дарга эдийн засгийн ухааны доктор, тэр эрдмийн зэрэг энэ тэр юмнуудыг бол бүүр тодорхой энэ дээр шалгуур үзүүлэлт дээр зааж өгмөөр байгаа юм.

Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх, Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалал энэ заавал байх ёстой юм уу? Ер нь Монгол Улсын иргэн энэ албыг хаших байх л даа тийм ээ. Тэгэхээр заавал тэр өөр улсын иргэний харьяалал гээд энд энэ заавал орох уу, заавал бичигдэх үү? Харин тийм. Тэгэхээр энд заавал энэ заавал орох уу гэж байгаа байхгүй юу? Боловсролын зэрэг дэвийг жоохон ахиулж тавьж өгмөөр байна. Үнэхээр эрдмийн зэрэг дэв гэдэг юм энд заавал байх ёстой санагдаж байгаа юм.

Түүрүүн тэр ашиг сонирхлын зөрчил банк бус санхүүгийн байгууллага энэ бол үнэхээр түгээмэл явж ирлээ. Тэгэхээр энийг хориглосон, тэр ашиг сонирхлын юун дээр хамаатан садан тэр хүмүүсийг нь хүртэл энд бүүр зааж өгмөөр байна л даа. Тэрийг оруулж зааж өгмөөр байна гэж би бодож байна.

Р.Сэддорж: Хариулт ажлын хэсэг индрийн микрофон нээе.

Д.Мягмарцэрэн: Нэр дэвшигчийн анкетын загварыг бол ерөнхийдөө бүх Байнгын хороод ижилхэн Их Хурлын харьяа байгууллагуудын албан тушаалтнууд дээр бол ижилхэн ингээд тавигдаж байгаа. Тэгээд одоо энэ яг

Эдийн засгийн байнгын хорооны харьяалах албан тушаалтнуудыг бол Байнгын хорооны гишүүд одоо ингээд ямар хүмүүсийг нэр дэвшүүлэх вэ гэдгээ ингээд ярилцаж шийдвэрлэж байгаа учраас шалгуур дээр бол нээлттэй гишүүд ямар санал гаргах нь.

Гэхдээ зүгээр хуулиас давсан шаардлага шалгуур тавьчихвал жоохон боломжгүй болчихно. Нөгөө нэр дэвшигчийн тоо нь хязгаарлагдчих байх. Ер нь бол ингээд нэр дэвшигч нар өөрсдийнхөө нөгөө дэлгэрэнгүй анкет, тэгээд холбогдох бүх материалуудаа заавал гаргаж өгөх үүрэгтэй байж байгаа. Байнгын хорооны гишүүд тэд нараас нь харж байгаад, ирүүлсэн материалуудаас харж байгаад, яг сонгох нэр дэвшигчээ нөгөө сонсголын үеэр тухайн нөгөө нэр дэвшигчтэй ярилцлага хийж сонгоод, тэгээд сонгогдсон нэр дэвшигчдийг Их Хуралд оруулж танилцуулдаг ийм дэгтэй байгаа.

Тийм болохоор тухайлан заавал яг ийм хүн байна гэж бас зааж болохооргүй байгаа. Тэгэхээр хэтэрхий нөгөө нэг шалгуурыг нарийсгаад тавьчихаар зарим тохиолдолд ямар шүүмжлэл гардаг вэ гэхээр хэн нэгэн хүнд зориулсан юу тавьчихлаа гэж, шалгуур тавьчихлаа гэсэн тийм шүүмжлэл гардаг. Зөвхөн тэр хүнд л ингээд зориулаад, тэр хүний нөгөө нэг байдалд нь тохируулаад мэдлэг, ур чадварт нь тохируулаад ингээд шалгаруулалт явууллаа гэсэн шүүмжлэл гардаг учраас шалгуурууд бол ерөнхий байдлаар тавигдаж байгаа. Хуульд угаасаа ямар, ямар шалгуурууд байх, нөгөө банк, санхүүгийн байгууллагад 10 жил ажилласан байх энэ тэр, удирдах албан тушаалд 5 жил ажилласан байх гэсэн шалгуурууд нь тэртээ тэргүй байгаа учраас энэ анкет дээр бол тэгж шалгуурыг бүүр нарийвчлах шаардлагагүй болов уу л гэж бодож байгаа.

Р.Сэддорж: Батчимэг гишүүн тодруулга асууя. Микрофон нээе.

П.Батчимэг: Хэн нэгэн хүнд зориулсан гэхээсээ илүүтэй энд бид нар ач холбогдол өгч, үнэхээрийн нэр дэвшигчид юунд их тийм няхуур хандах гэж байгаа болбол заавал тэр боловсролын зэрэг дэв ер нь бол байх ёстой шүү дээ. Тэгээд сая бол өөрийн чинь хэлсэн юман дээр би сайн ойлгосонгүй л дээ. Ер нь бол энэ дээр өөрчлөлт оруулж болох уу л гэж би бас юугаа асууж байгаа юм?

Р.Сэддорж: Хариултыг тодорхой ажлын алба. Индэрийн микрофон.

Д.Мягмарцэрэн: Энэ анкетын нөгөө нэг асуултууд, шалгуурууд дээр бол нэмэх, хасах эрх нь бол Байнгын хорооны гишүүдэд бүгдэд нээлттэй байгаа. Түрүүн Байнгын хорооны дарга ч тайлбарласан. Шаардлагатай бол илүү шалгуур нэмье, шаардлагагүй асуудлуудыг нь хасах боломжтой.

Р.Сэддорж: Тэгээд энэ тодорхой юм хэлээд байна шүү дээ. Тэгээд эрдмийн зэрэг цол ядаж энэ чинь нэг цаасан дээр ажиллаад сурчихсан, доктор цолтой эд нар хүн байх ёстой байлгүй дээ. Байгаа юм уу тийм ээ, байгаа юм байна. Хамгийн ар тал дээр нь байгаа юм байна. Тийм байна. Боловсролын зэрэг, магистраас дээш гэж. Тэгээд ингээд гишүүний хэлсэн үг бол протоколд тэмдэглээд, протоколд тэмдэглэгдэж байгаа. Тэгээд энэ гишүүдийн санал, гарсан саналуудыг тусгахыг ажлын албанд үүрэг чиглэл болгож байна. Санал дээрээ хэлчихгүй юү? Санал, асуулт асууж дууслаа. Саналтай гишүүд, Энхтүвшин гишүүнээр саналыг тасаллаа. Санал хэлье. Бадамсүрэн гишүүний микрофоныг нээе.

М.Бадамсүрэн: Түрүүн би асуусан. Энэ анкетын маягтыг хаанаас авч боловсруулсан бэ гээд. Тэгээд хариулт өгөхдөө бол тухайн Монголбанк, ҮСХ гээд тэндээс авсан гэж ойлголоо. Тэгэхээр ямар санал байна гэхээр энэ хуулиудыг сая бүгдийг нь үзлээ. Энэ чинь нэлээн тодорхой шалгууртай юм байна шүү дээ. Магистраас дээш зэрэгтэй байх,

мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх, мөн зөвхөн Монгол Улсын иргэн байх, улс төрийн намын удирдах албан тушаалтан байхгүй, Их Хурлын гишүүн, ЗГ-ын гишүүн байхгүй гээд. Тэгээд тийм учраас энэ анкет дээр энэ хуульд заасан тодорхой нийтлэг болон тусгай шаардлага нь энэ дээрээ асуулга байдлаар тавих нь зүйтэй гэж үзэж байгаа юм.

Нэгэнт л маягт баталж байгаа юм бол маягт чинь маш ойлгомжтой байх хэрэгтэй. Энэ Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 30.6, 30.7 дээр ер нь л тодорхой заачихсан байна шүү дээ. 30.6 дээр ингээд нэр дэвшигчийн дэлгэрэнгүй танилцуулга, томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, тухайн албан тушаалд тавих хуульд заасан нийтлэг болон тусгай шаардлагын талаарх мэдээллийг авах маягтын загварыг Байнгын хороо батална. Энэ хуулийн 30.6-д заасан загварт заасан мэдээллийг нэр дэвшигчээс өөрөөс нь гаргуулна гээд.

Тэгээд энийг нөгөө нэг бусад хуультайгаа уялдуулаад нөгөө ил тод Нийтийн ил тод байдлын тухай хууль, Хувь хүний нууцын тухай бас хууль байгаа. Энэтэйгээ уялдуулаад ингээд яг анкет дээр юу ямар мэдээллийг энэ Их Хурал томилохдоо нэр дэвшүүлэхдээ энийг заавал мэдсэн байх ёстой вэ гэдгийг маш тодорхой болгож өгөх шаардлагатай гэж үзэж байгаа юм. Тэгэхгүй бол энэ яг энэ анкетаар авах юм бол хуульд заасан нөгөө нийтлэг болон тусгай шалгуурыг энэ дээрээс бол харж чадахгүй харагдаж байгаа байхгүй юу. Харин нөгөө талдаа дахиад нөгөө бусад зарим төрлийн асуулгууд нь яг энэ дээр нийцэх үү, нийцэхгүй юу, нөгөө хөрөнгө орлогын мэдүүлэг, ашиг сонирхлын мэдүүлгийг мэдүүлдэг энэ асуулттайгаа энэ асуулгатайгаа ижил байна уу эсвэл энийг яаж зааглах юм гээд энэ зүйлүүд дээрээ анхаараач гэсэн саналыг хэлж байна. Би тэгээд анкет дээрээ бол энийг яг хуульд заасан тэр зүйлийг нь тодорхой

оруулах нь зүйтэй л гэж үзэж байгаа юм. Маш тодорхойгоор, баярлалаа.

Р.Сэддорж: Гишүүний саналыг протоколд тэмдэглэж байна. Дараагийн гишүүн Соронзонболд гишүүний микрофоныг нээе.

Л.Соронзонболд: Нэр дэвших хүсэлтийн ар талын хамгийн 2.1-ийн дараа эрх бүхий байгууллагаас нэр дэвшүүлсэн албан бичиг шийдвэр гээд нэг юу байна л даа. Тэгэхээр нөгөө холбогдох албан тушаал бүр дээр яг эрх бүхий байгууллага нь ямар байгууллага байгаа вэ гэдэг талаар мэдээллийг Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд бас явуулчихвал зүгээр байна гэсэн нэг ийм санал байна.

Р.Сэддорж: Баярлалаа. Батиугар гишүүний микрофоныг нээе.

Э.Батиугар: Баярлалаа. Энэ зориуд протоколд оруулах гээд хэлэх гэсэн юм. Бид нар маягт л баталж байгаа шүү дээ. Хуульдаа шаардлагууд заачихсан байгаа юм, ямар. Тэгэхээр маягтдаа нэг юм анхаараарай гэж хэлэхэд хуулиа түрүүн бас хэлж байна. Хуулиас давсан тийм шаардлага байхгүй. Зүгээр харин маягтаа л нэг ёсондоо анкет гэсэн үг шүү дээ энэ. Тэрний маягтын загварыг нь бид нар баталж байгаа шүү гэж хэлмээр байна. Тэгэхээр заавал бүр гүнзгий заасан зүйл хэрэггүй гэж бодож байна. Тэгж хаагаад, маягтаар хаана гэж байхгүй л дээ, хүн томилогдох гэж байна уу, үгүй юу гэдэг нь. Харин хуулиараа маш тодорхой заачихсан байдаг шаардлагаа. Тэрийг анхаараарай л гэж хэлэх гэсэн юм.

Р.Сэддорж: Баярлалаа Энхтүвшин гишүүний микрофоныг нээе.

Д.Энхтүвшин: Түрүүн Батчимэг гишүүний нөгөө хэлсэн санал дээр би бас яах вэ тэрэн дээр жоохон эсрэг өөр бодолтой байгаа. Тэгээд заавал эрдмийн зэрэг цол гэдэг юм шаардлага тавьж хязгаарладаг юмнууд бас ер нь дэмий юм

шиг санагдсан. Их сургуулийн жишигээр удирдлага, удирдах зөвлөлд байдаг тэнд нөгөө тийм шаардлагууд тавиад цөөхөн хэдэн хүн тэгээд өрсөлдөж чадахгүй болчихдог тийм асуудлууд гардаг юм байна лээ. Тэгэхээр түрүүн бас тэгээд протоколд ороод, заавал тэгэх ёстой гээд явчих вий гэж бодоод хэлж байгаа юм.

Яг Монголбанкны Төв банкны тухай хууль дээр болохоор Ерөнхийлөгч болон Дэд ерөнхийлөгчид эдийн засаг, банк санхүү, удирдлагын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн ёс зүй, ажлын туршилагыг харгалзана гэсэн болохоос биш бас яг магистр гэсэн юм бол байхгүй л харагдаад байна л даа. Тэгэхээр тэгж хатуу нөгөө нэг шалгууруудыг ер нь бол манай эрдмийн зэрэг цол олгож байгаа үйл явц чинь ямар билээ, жишигээр магистр, тэгээд доктор ч гэдэг юм уу энэ үйл явц маань чанар нь хангалттай биш байдаг учраас заавал тэгж хүмүүсийн тэр сонголтыг хязгаарлах хэрэггүй юм шиг санагдаж байна. Тэгэхээр тэгж оруулаад хэрэггүй гэдэг дээр саналаа хэлье гэж бодсон юм.

Р.Сэддорж: Энэ чинь хоорондоо ингээд үг солилцож байна шүү дээ. Энийг чинь заавал зогсоож хэрэггүй. Батсүмбэрэл гишүүний микрофоныг нээе.

Н.Батсүмбэрэл: Зарим санал нь сая давхардаж байна. Тогтоол нэгэнт ингээд өнөөдөр батлагдах нь байна. Тэгээд батлагдаж байгаа учраас өнөөдрөөс нээлттэй олон нийтэд зарлаад явах нь зохимжтой байна 1 дүгээрт.

2 дугаарт сая Байнгын хорооны ажлын албанаас өгсөн мэдээлэл хангалтгүй л байна. Энэ чинь зарим субъектүүд тэр статистикийн байгууллага энэ тэр гээд алга байна. Тэгээд хугацаа нь дуусчихсан нэгэнт орон тоонууд дээр бол өнөөдрөөс нэгэнт тогтоол гарчих юм чинь сонгож, нөгөө нээлттэй зарлах хэрэгтэй.

2 дугаарт энэ сард багтаагаад хэд хэдэн субъектүүд дуусах юм байна. Энэ сараас эхлээд. Эд нарыг нь бол тухай тухайд нь шуурхай зарлаад явах нь бол оновчтой болов уу гэж бодож байна тэгээд ингэж.

Саяын ярьсан тэр юун дээр Батшугар гишүүн нэлээн тодорхой юу хэлчхэж байна. Бас өөрөө Монголбанканд ажиллаж байсан хүн ч учраас нөгөө нарийн шалгуурууд зохицуулалтууд бол хууль дээр байж байна, байж байгаа юм байна тийм ээ. Тэгэхээр тэрийг бид нар харгалзаж, энэ чинь нөгөө дөнгөж сая хурал дээр тараагдсан материал шүү дээ. Тийм учраас бид энийг Монголбанкны хууль, СЗХ-ны хууль, Статистикийн хууль гээд энэ хуулиудыг тодруулж хараагүй учраас ер нь нээлттэй сонсголын тэр процессыг сайн мэдэхгүй байгаа учраас энийг тодорхой мэдээлэлгүй байж болзошгүй гишүүд.

Гагцхүү нэгэнт өнөөдөр батлагдаж байгаа тогтоолоо өнөөдрөөс эхлээд нээлттэй зарлаад, аль, аль албан тушаалууд би түрүүн асуулт дээр зориуд асуусан нь тэр. Энэ 9 нийт субъект хэдэн ажлын байрыг хийж байгаа юм бэ гээд. 20 гаруй ажлын байр гэж байгаа юм. Тэр дотроос ялангуяа эхлээд онцлоход Монголбанкны хяналтын зөвлөл, бодлогын зөвлөл гэх мэт субъект бол бүрэн бүрэлдэхүүнээрээ хугацаа нь дуусчихсан байна. Тэгэхээр энийг яг өнөөдөр нэгэнт тогтоол батлагдаж байгаа юм чинь өнөөдрөөс эхлээд нийтэд зарлах нь зөв гэж зориуд хэлж байна.

Р.Сэддорж: 2 хяналтын зөвлөлийн хугацаа нь дууссан байгаа СЗХ, Монголбанкны. Гишүүд санал хэлж дууслаа. Санал хураалтыг явуулж эхэлье. Тэгээд энэ санал хураалтын эхэнд бол сая Батшугар гишүүний хэлснээр хуульд бол бусад юмнууд нь бүгдээрээ орчихсон байгаа. Бид нар бол өнөөдөр зөвхөн загварыг нь баталж байгаа. Гэхдээ анкетын загвар. Загвар дээр бол энэ 1.8 эд нар бол ёстой хүний эрх рүү алдчихсан юм

л явж байна. Тэгээд энийг бас хасахыг протоколд, энэ чинь гүтгээд ч орчихсон байж, юу тодорхойлуулчихсан байж мэднэ шүү дээ. Тийм учраас энийг шүүхээр шийдвэрлээгүй юмыг бол энд бичиж болохгүй байх гэдэг саналыг хэлье.

Нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Энэ манай Байнгын хорооны л ажил л даа. Бид нар бүгдээрээ нээлттэй аваад л, тэгээд л энэ дээрээ сонгон шалгаруулна л гэж ойлгоод байгаа. Өмнө нь бол ийм анкетын загвар ч байхгүй байсан юм байна. Тэгээд одоо их л цэгцтэй болгох гэж явж л байгаа асуудал. Редакцын, сая Бадамсүрэн гишүүний энэ саналыг оруулаад, редакцын засвартайгаар Нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг редакцын засвартайгаар баталъя гэсэн Байнгын хорооны гишүүд баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 84,6 хувийн саналаар тогтоол батлагдлаа. Батшугар гишүүний юу ажиллаагүй юу, болчихсон уу? Батчимэг гишүүнийг протоколд тэмдэглүүлье. Төхөөрөмж ажиллахгүй байна. Батчимэг гишүүн дахиж өгсөн үү энэ хурууны хээгээ, ер нь юунд очиж, дахиад уу? Санал хураалт явуулж дууслаа. Нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа. Дараагийн асуудалд оръё. Редакцын засвартайгаар энэ санал хураалтыг сая баталлаа 84,6 хувийн саналаар.

11.41 цаг

Хоёр. Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргыг сонгох тухай/

Хэлэлцэх асуудлын 2 дугаарт, 2 дугаар асуудалдаа оръё. Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргыг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Ингээд хамтарсан Засгийн газар, намуудын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа энэ 4 жилийн хугацаанд манай Байнгын хорооны ганц дэд хороо байдаг. Энийг Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёлыг нэр дэвшүүлснийг танилцуулж байна. Дэд хорооны даргад нэр дэвшүүлэх талаар өөр саналтай гишүүд байна уу? Байна уу? Байхгүй байна. Нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Асуулт асууж, тэгсэн зөвшилцсөн юм. Тэгээд та асуучихгүй одоо, нэрээ өгчихгүй юу? Алтанишагай гишүүнээр асуулт асууж, үг хэлэх гишүүдийн нэрсийг тасаллаа. Алтанишагай гишүүний микрофоныг нээе.

Н.Алтанишагай: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Дэд хорооны дарга дээр нэр орж ирж байна. Сэддорж дарга энэ ямар удирдлагатай зөвшилцсөн бэ? Сэддорж дарга.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын дэд хороо байгуулах Улсын Их Хурлын даргын тогтоол байгаа. Энэ тогтоолд орсон гишүүд бол 10 хүн байгаа. Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо энэ 10 хүнээсээ 1-ийг нь тодруулах ёстой. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Отгоншарын Батнайрамдал, Пүрэвийн Батчимэг, Энхбаярын Батшугар, Батбаярын Жаргалан, Мэндбаярын Мандхай, Баатаржавын Мөнхсоёл, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Агваанлувсангийн Ундраа, Мөнхчулууны Энхцэцэг гэсэн ийм 10 гишүүн бол энэ Тогтвортой хөгжлийн дэд хороонд байна.

Ингээд намын бүлгийн дарга нар хоорондоо зөвшилцсөний үндсэн дээр Баатаржавын Мөнхсоёл гишүүнийг энэ дэд хорооны даргаар тавиагч гэсэн ийм шийдвэрийг надад уламжилсан. Энэ саналыг оруулж ирж байгаа юм. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулъя. Монгол Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын

Мөнхсоёлыг Монгол Улсын Их Хурлын Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргаар сонгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 92,3 хувийн саналаар дэмжигдлээ. Энхтүвшин гишүүний төхөөрөмж уншаагүй байна, энийг протоколд тэмдэглүүлье. Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргыг сонгох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10, 27.11 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг, санал хураалтын дүнг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёлыг сонгосугай. Эдийн засгийн байнгын хороо. Ингээд тогтоолын төслийг уншиж танилцууллаа. Тогтвортой хөгжлийн дэд хорооны, Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргыг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

11.47 цаг

Эдийн засгийн байнгын хорооны хуралд, өнөөдрийн хурлын хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаа идэвхтэй оролцсон та бүхэндээ баярлалаа. Мөнхсоёл гишүүндээ, Мөнхсоёл даргадаа баяр хүргэе. Манай ганц дэд хорооны дарга боллоо. Тэгээд Монгол Улсынхаа хөгжил, дэвшлийн төлөө их зүйлийг хийж гүйцэтгээрэй. Баяр хүргэе.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Д.УЯНГА

